



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 31 өдөр

Дугаар А/187

Чингис хот

Хилийн цэргийн 0287 дугаар ангид  
дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.1-ын "а", 29.1.6-ын "а", Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.1, 58.2.20, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.3.2, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Хуралдааны 2017 оны 09 дүгээр тогтоол, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2019 оны 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хууль зүй, дотоод хэргийн сайдын Хэнтий аймгийн Засаг даргатай 2020 онд хамтран ажиллах талаар байгуулсан гэрээний 5 дугаар зүйлийн 5.2, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн Хууль сахиулах бодлогын 4.3.2 дах арга хэмжээний зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Хилийн 0287 дугаар ангийн алба хаагчдын 2 айлын орон сууц барихад 10 000 000 /арван сая/ төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга /Л.Бат-Октябрь/-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

231010482

БАТЛАВ  
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД ХИЛ  
ХАМГААЛАХ ТУСЛАХ ХҮЧНИЙ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Н.ГАНБЯМБА

ХИЛИЙН 0287 ДУГААР АНГИЙН АЛБА ХААГЧДЫН ОРОН БАЙРНЫ  
АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХЭД САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭ

2020 оны 03 дугаар сарын 30 ны өдөр

Чингис хот

Энэхүү захиалагч гүйцэтгэгчийн хоорондын гэрээ /цаашид "гэрээ" гэх/ Нэг талаас цаашид "Захиалагч" гэх)-ийг төлөөлж Хэнтий аймгийн Засаг Даргын Тамгын газрын дарга Ж. Ганбаатар /Нөгөө талаас: цаашид "Гүйцэтгэгч" гэх)-г төлөөлж Хилийн 0287 дугаар ангийн захирагч, хурандаа Н. Жаргалсайхан /цаашид хамтад нь талууд гэх/ нар нь Монгол Улсын Захиргааны Ерөнхий хууль заасны дагуу харилцан тохиролцож 2020 оны 03 дугаар сарын 30-ны өдөр Хэнтий аймгийн Чингис хотод байгуулав.

### Нэг. Гэрээний зорилго

Хууль зүй, дотоод хэргийн сайдын Хэнтий аймгийн Засаг даргатай 2020 онд хамтран ажиллах талаар байгуулсан гэрээний 5 дугаар зүйлийн 5.2, Хэнтий аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн Хууль сахиулах бодлогын 4.3.2 дах арга хэмжээний зорилтыг хэрэгжүүлэхэд оршино.

### Хоёр. Гэрээний зүйл

2.1. Гүйцэтгэгч нь захиалагчид Хууль зүй, дотоод хэргийн сайдын Хэнтий аймгийн Засаг даргатай 2020 онд хамтран ажиллах талаар байгуулсан гэрээний тавдугаар зүйлийн 5.2, Хэнтий аймгийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.3.2.2, заасны дагуу Хилийн 0287 дугаар ангийн алба хаагчдын 2 айлын орон сууцыг барихад дэмжлэг үзүүлэх үүргийг хүлээнэ.

2.2. Захиалагч нь энэ гэрээнд заасан дэмжлэгийг үзүүлэх үүргийг хүлээнэ.

### Гурав. Ажиллах нөхцөл

3.1. Талууд ажиллахдаа гэрээний агуулгад дурдсан асуудлаар бие биедээ өгсөн үнэлэлт, зөвлөмжийг анхааралдаа авна.

3.2. Талууд шаардлагатай арга хэмжээг авхуулах зорилтын үүднээс гүйцэтгэхэд саад болж буй бэрхшээлийн тухай бие биедээ нэн даруй мэдэгдэнэ.

3.3. Хэрэв гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн буюу хагас, эсвэл зохих хугацаанд биелүүлж чадахгүй бол талууд энэ тухай бие биедээ бичгээр мэдэгдэнэ.

3.4. Энэ гэрээний үүргийг биелүүлэх явцад гүйцэтгэгч захиалагчийн төлөөлөгчийн нэгэн адил ажиллана.

хуралдааны 08 дугаар тогтоолоор батлагдсан аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас 10.000.000 төгрөгийг санхүүжүүлнэ.

### Тав. Хариуцлага

5.1.Захиалагч, гүйцэтгэгчийн аль аль нь энэ гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй бол хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

### Зургаа. Гэрээ хүчин төгөлдөр байх

6.1 Талууд гэрээнд гарын үсэг зурсан үеэс гэрээ хүчин төгөлдөр болно.

### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН САНХҮҮ, ТӨРИЙН  
САНГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА  
 НЯМДАВАА


АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ХУУЛЬ, ЭРХ  
ЗҮЙН ХЭЛТСИЙН ДАРГА  
 Л.БАТ-ОКТЯБРЬ

(гарын үсэг)  
тэмдэг

ХИЛИЙН 0287 ДУГААР АНГИЙН  
ЗАХИРАГЧ,  
ХУРАНДАА

 Н.ЖАРГАЛСАЙХАН

ХИЛИЙН 0287 ДУГААР АНГИЙН  
САНХҮҮГИЙН ТАСГИЙН ДАРГА,  
АХМАД

 Х.ГАНТУЛГА

(гарын үсэг)  
тэмдэг


  
 БАТЛАВ  
 ХИЛИЙН 0287 ДУГААР АНГИЙН ЗАХИРАГЧ,  
 ХУРАНДАА Н.ЖАРГАЛСАЙХАН

2020 оны 02 дугаар сарын 20

**2 АЙЛЫН ОРОН СУУЦНЫ БАРИЛГА БАРИХАД ШААРДЛАГАТАЙ БАРАА МАТЕРИАЛЫН  
ТООЦОО СУДАЛГАА**

д/д	Материалын нэрс	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт дүн	Тайлбар
<b>Суурийн ажил</b>						
1	Цемент	тн	3.3	180,000	594,000	
2	Арматур ф-18	м	166	4,500	747,000	
3	Катанка ф-8	м	500	600	300,000	
4	Төмөр угас	боо	3	25,000	75,000	
5	Хар панер	ш	16	22,000	352,000	
<b>Дүн</b>					<b>2,068,000</b>	
<b>Шалны ажил</b>						
1	Паркет шал	м2	84	14,500	1,218,000	
2	Паркет шалны хүрээ	м	95	1,250	118,750	
3	Паркет шалны булан	ш	50	250	12,500	
4	Паркет шалны залгаас	ш	40	250	10,000	
<b>Дүн</b>					<b>1,359,250</b>	
<b>Хаалга, цонхны ажил</b>						
1	Бүргэд хаалга/2.1*0.96/	ш	2	300,000	600,000	
3	Модон хаалга/2.1*0.7/ 12 хроп	ш	2	90,000	180,000	
5	Модон хаалга/2.1*0.8/ 25 хроптой	ш	2	90,000	180,000	
6	Вакум цонх/1.5*1.5/	ш	4	152,000	608,000	
7	Вакум цонх/1.5*2.0/	ш	2	182,000	364,000	
9	Цонхны тавцан/1.5*0.3/	ш	6	25,000	150,000	
12	Хөөс	ш	12	4,500	54,000	
13	Хаалганы бариул	ш	4	30,000	120,000	
<b>Дүн</b>					<b>2,256,000</b>	
<b>Хучилтын ажил</b>						
1	Ус чийг тусгаарлагч	м2	95.2	4,000	380,800	
2	Хадаас 100мм 7 кг	хай	5	15,000	75,000	
3	Хадаас 120мм 6кг	хай	5	15,000	75,000	
4	Палкны хадаас	боо	5	22,000	110,000	
6	Дулаалгын хөөсөнцөр	м2	95.2	3,000	285,600	
<b>Дүн</b>					<b>926,400</b>	
<b>Дээврийн ажил</b>						
1	Дээврийн төмөр 3.9м	ш	34	25,000	850,000	
2	Малгай төмөр	м	16	2,000	32,000	
3	Дээврийн шрүп	хай	5	16,000	80,000	
<b>Дүн</b>					<b>962,000</b>	
<b>Дотор заслын ажил</b>						
1	Дүүжин тааз	м2	65	7,500	487,500	
2	Цемент	тн	2	180,000	360,000	

3	Эмульс 18 кг	лааз	6	20,000	120,000
4	Замаск 20кг	уут	10	7,500	75,000
5	107 цавуу	ш	25	2,000	50,000
<b>Дүн</b>					<b>1,092,500</b>
<b>Дотор гэрэлтүүлгийн ажил</b>					
1	Оруулгын кабель 4*25мм	м	40	5,000	200,000
2	Монтажны утас 2*3,5	м	70	1,200	84,000
3	Хроп	ш	6	1,500	9,000
4	Унтраалга	ш	8	4,500	36,000
5	Разетка 16А	ш	6	4,000	24,000
6	Гэрэлтүүлэг	ш	10	22,000	220,000
<b>Дүн</b>					<b>573,000</b>
<b>Нийт дүн</b>					<b>9,237,150</b>
<b>Модны төлбөр</b>					<b>765,000</b>
<b>Нийт дүн</b>					<b>10,002,150</b>


ХЯНАСАН:

АР ТАЛ ХАНГАЛТЫН ДАРГА,

ДЭД ХУРАНДАА  Д.БАТ

САНХҮҮГИЙН ТАСГИЙН ДАРГА,

ЕРӨНХИЙ НЯГТЛАН/БОДОГЧ,

АХМАД  Х.ГАНТУЛГА

СУДАЛГАА ГАРГАСАН:

БАРИЛГА ОРОН СУУЦНЫ АЛБАНЫ ДАРГА,

ХОШУУЧ  Б.ОТГОНЦЭРЭН